



Б.ЗАМБАГА
*Өвөрхангай аймгийн
 Шүүхийн шийдвэр
 гүйцэтгэх албаны шийдвэр
 гүйцэтгэгч*

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАТАЛГАА, ЦААШИД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль⁶⁰, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ⁶¹. Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч нь Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана, мөн зүйлийн 3-т төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно⁶²”, Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна⁶³” хэмээн төрийн албан хаагчийн эрх зүйн баталгааг хэрхэн тогтоох, хангах арга зам, үүргийг зааж эх сурвалжыг тогтоож өгсөн.

Төрийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулхад түүний албан хаагчийн ажиллах нөхцөл, эрх зүйн болон нийгмийн баталгаа, эрүүл мэндийг хамгаалах, хангахтай холбогдсон асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ нь төрийн өөрийнх нь үүрэг юм. Энэхүү үүргийнхээ хүрээнд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйл, эрх зүйн нийтлэг жишигт тулгуурласан Монгол Улсын 1992 оны дөрөвдүгээр Үндсэн хуулийн үзэл баримтлал, бодлого, эрх зүйн шинэтгэлийн дагуу Төрийн албанд холбогдох нийгмийн харилцааг дагнан зохицуулсан анхы Монгол Улсын Хууль 1994 онд батлан гаргасан, Улсын их хурал Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцэн, боловсронгуй болгон нэмэлт хийж, баталсан хууль одоо хүчин төгөлдөр үйлчилж байна⁶⁴. Тус хуульд төрийн албан тушаалын ангилал, төрийн ямар албан тушаалд аль нь хамаарахыг нэг бүрчлэн зааж өгсөн.

Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ⁶⁵. Төрийн албыг эрхлэж байгаа ажил үүрэг, албан тушаалын онцлогоос нь хамааран: Төрийн улс төрийн алба, албан хаагч, төрийн

⁶⁰ Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992.. Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1992 оны №1 нийтлэгдсэн..

⁶¹ Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, УБ., Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2002 оны №28 нийтлэгдсэн., 3 дугаар зүйл.,

⁶² Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992., 46 дугаар зүйл., Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1992 оны №1 нийтлэгдсэн.,

⁶³ Монгол Улсын Үндсэн Хууль, 19 дүгээр зүйл., 19.1 дэх хэсэг., УБ., 1992.. Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1992 оны №1 нийтлэгдсэн.,

⁶⁴ Төрийн албаны тухай хууль 2002 онд батлагдан гарч үйлчилж эхэлсэнээс хойш нийт 26 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. 2013 оны 10 дугаар сарын 29 ний байллаар..

⁶⁵ Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, УБ., Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2002 оны №28 нийтлэгдсэн., 11 дүгээр зүйл, 11.1 дэх заалт., Монгол улсын хүн амын тоо 2,920,803 хүн
http://www.nso.mn/index.php?page=menu&m_id=258&s_id=0/ үүнээс төрийн албанд 162,769 үүнээс төрийн тусгай албанд нийт 16179 хүн ажиллаж байгаагаас шшгег-ын харьяа хорих анги, албадад 3032 үүнээс 219 нь ШГГазарт харьяалагдан шийдвэр гүйцэтгэгчээр ажиллаж байна.

захиргааны алба, албан хаагч, төрийн тусгай алба, албан тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагч хэмээн ангилан үздэг.

Төрийн захиргааны, төрийн тусгай албан тушаалын ангиллын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг мэргэшлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг төрийн жинхэнэ албан хаагч гэнэ⁶⁶.

Төрийн дээрхи албан тушаалуудад тавих ерөнхий шаардлага нь (хуульд өөрөөр заагаагүй бол) тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай, мэргэшсэн байхыг шаардах ба энэхүү шаардлагыг хангаж⁶⁷, төрийн албанд ажиллаж, төрийн зорилт чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагч нь Монгол Улсын Үндсэн хууль болон Төрийн албаны тухай хууль бусад ердийн хуулиудад заагдсан эрх зүйн баталгааг эдэлнэ.

Эрх зүйн баталгааг ерөнхийд нь тодорхойлон авч үзвэл “хуульчлан тодорхойлсон эрхийг бодитой хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хангахад чиглэгдсэн нийгэм, эдийн засаг, улс төр, үзэл суртал, хууль зүйн цогц ойлголт ” гэж тодорхойлож болох юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч төрийн тусгай албан хаагч болох нь: онцлог, чиг үүрэг:

Төрийн эрх мэдлийн нэгэн тулгуур нь шүүх эрх мэдэл бөгөөд энэхүү эрх мэдлийн хэрэгжилтийн биелэлтийг Засгийн

газрын хэрэгжүүлэгч агентлаг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар Тогтоол гүйцэтгэх газар, Шийдвэр гүйцэтгэх газраараа дамжуулан төрийн зорилт чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн хэв журмыг хамгаалахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараах албан тушаал хамаарна, 8.1.6. “зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч, **шүүхийн шийдвэр гүйцэтгэгч**⁶⁸, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн” хамаарна, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 дэх хэсэгт “Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь шийдвэр гүйцэтгэгч болон хорих байгууллагын албан хаагчаас бүрдэнэ” мөн хуулийн 132 дугаар зүйлийн 132.2 дах хэсэгт “шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь төрийн төлөөлөгч мөн” хэмээн зааж **шүүхийн шийдвэр гүйцэтгэгч төрийн төлөөлөгч, төрийн тусгай албан хаагч** болохыг эрх зүйн хувьд баталгаажуулж өгсөн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь ял шийтгэлгүй, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтаар тэнцсэн Монгол Улсын иргэн байх бөгөөд үйл ажиллагаагаа хэрэгжүүлсний төлөө Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг баталгаанаас гадна

⁶⁶ Төрийн албаны тухай хууль, 11 дүгээр зүйл, 11.2 дах хэсэг, УБ., 2002.. Төрийн мэдээлэл эмхтгэлийн №28 нийтлэгдсэн..

⁶⁷ Монгол Улсын Үндсэн Хууль, 19 дүгээр зүйл, 4 дэх хэсэг.. Төрийн мэдээлэл эмхтгэлийн №28 нийтлэгдсэн.. Монгол Улсын Иргэн “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, ... эрхтэй” гэж заасан.,

⁶⁸ Шийдвэр гүйцэтгэгч нь Улсын ерөнхий гүйцэтгэгч, ахлах гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчээс бүрдэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан эрх зүйн баталгаагаар хангагддаг⁶⁹.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгаа: Цаашид анхаарах зарим асуудал

Шүүхийн шийдвэр⁷⁰-ийг биелүүлэх хүнд, нэн хариуцлагатай ажлыг төр ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг болох төр нийгмийн байгуулал, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх чухал үүргийг саадгүй биелүүлж ирсэн.

Гэвч шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь төрийн өмнө хүлээсэн "хууль дээдлэх, хүний

эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй байх"⁷¹ зарчимд тулгуурлан иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад эх зүйн баталгаа, хамгаалалт дутмаг байдгаас шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй, хараат бус байдал алдагдах, шийдвэр гүйцэтгэгчийн амь бие, эрүүл мэнд, хууль ёсны эрх ашиг сонирхол төрийн хууль ёсны хамгаалалтын гадна үлдэж, хохирох асуудал алхам дутамд тохиолдож байгаа нь явцуу утгаар нь авч үзвэл Үндэсний аюулгүй байдал, өргөн утгаар нь авч үзвэл шүүх эрх мэдлийн хэрэгжилт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны шуухай байдал, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг хүндэтгэх иргэдийн сэтгэл зүйд сөргөөр нөхөөлөх олон сөрөг асуудлыг хөндөж байна.

Улс орны нийгмийн хөгжилтэй уялдан гэмт хэрэг, халдлага даяарчлагдаж, улам бүх зохион байгуулалтанд орж, үйлдлийн арга нарийсч байгаа өнөө үед төрийн албан хаагчдад итгэж, хүндэтгэлтэй хандаж ирсэн нийгмийн сэтгэл зүй өөрчлөгдсөн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, албадын орон байр, материаллаг техник хангамж бэхжээгүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгаа хангалтгүй, шийдвэр гүйцэтгэх алба багийн, хамтын ажиллагааны системд шилжээгүй зэрэг нь шийдвэр гүйцэтгэгч мэргэшлийн болж хөгжиж, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчим бүрэн хэргэжхэд ихээхэн нөлөөлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн үйлдэл,

⁶⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль..137 дугаар зүйл., УБ., 2002.. Төрийн мэдээлэл эмхтгэлийн №8 нийтлэгдсэн., 137.1.1.албан үүргээ гүйцэтгэж байх үедээ нийтийн тээврийн хэрэгсэлээр зорчсон зардлыг тогтоосон журмын дагуу байгууллагаас нөхөн авах: 137.1.2.албан үүргээ биелүүлж яваад амь. насаа алдсан тохиолдолд ар гэрт нь түүний 5 жилийн үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгох: 137.1.3.албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвар түр алдсан, тахир дутуугийн тэтгэмж авч байсан нийт хугацаанд олгох ба хэрэв дээр дурдсан шалтгаанаар хохирсноос хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлыг улсын төсвөөс авах: 137.1.5.шилжин томилогдох үед гэр бүлийн гишүүд болон ачаа тээврийн байгууллагын тээврийн хэрэгсэлээр хүргэх боломжгүй бол шаардагдах зардлыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож олгох: 137.1.6.офицер, ахлагч ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт очиж, ирэх бол замын зардлыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгох. 137.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, эрүүл мэндээр халагдах болон амины сууч барих, орон сууц худалдаж авахад нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу тусламж, хөнгөлөлт үзүүлж болно. 137.6.Шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэхийг хориглоно. 137.7.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан хууль ёсны шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх ба биелүүлэхгүй бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 137.8.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй. 137.9.Бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно. 137.10.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, албан хаагч тэтгэвэрт гарахаас өмнө 1 жилийн дотор төрийн зардлаар тодорхой сургалтанд хамрагдана.

⁷⁰ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар., 183 дугаар зүйл, 183.1 дэх хэсэг., УБ 2008., 429 дэх тал.,

⁷¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль..3 дугаар зүйл., 3.1 дэх хэсэг., УБ., 2002.,

шийдвэрийг эсэргүүцэх, улмаар амь нас, эрүүл мэндийг хохироох явдал өссөн, шийдвэр гүйцэтгэгчийн мэргэжлийн үйл ажиллагааг ойлгодоггүй нь тэдний аюулгүй байдал, эрх зүйн хамгаалалт, баталгаа бүрдээгүйтэй холбоотой.

Монгол Улсын хэмжээнд нийт 184 шийдвэр гүйцэтгэгч, 35 ахлах гүйцэтгэгч ажиллаж байгаагаас 72 гүйцэтгэгч, 7 ахлах гүйцэтгэгч нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд, 112 гүйцэтгэгч, 28 ахлах шийдвэр гүйцэтгэгч хөдөө орон нутагт ажиллаж байна. Эдгээрээс Нийслэлийн ШГАлбаны 5, Орхон аймаг дах ШГАлбаны 10, Өмнөговь аймаг дах ШГАлбаны 6, Сүхбаатар аймаг дах ШГАлбаны 3, Дорноговь аймаг дах ШГАлбаны 6, Өвөрхангай аймаг дах ШГАлбаны 5, Өвөрхангай аймгийн Хархорин дах ШГАлбаны 2, Завхан аймаг дах ШГАлбаны 4, Говь-Алтай аймаг дах ШГАлбаны 1 нийт 42 гүйцэтгэгчийн хамруулан авсан анкетийн судалгааг асуулга тус бүр дээр дүгнэж үзвэл:

1. Таны амьдарч буй орчин асуултын хүрээнд

- А. Байранд 2
- В. Гэрт 8
- С. Хувийн байшинд 7
- Д. Түрээсийн байранд 14
- Е. Албаны байранд 9
- Ф. Айлд суудаг 2

Айлын хажуу өрөө болон түрээсийн байранд амьдардаг 11 гүйцэтгэгч байна энэ нь төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 заасан орон байраар хангагдах эрх нь хэрэгжихгүй байна.

Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд харъяалалын сумдаараа явахдаа дор хаяж 3 өдөр явдаг. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бодит ажиллагаагаар дамжин үр дүнтэй түргэн шуурхай биелэгддэг ба шийдвэр

гүйцэтгэгч нэг ажиллагаанд явахад дундажаар 4 цагийг зарцуулдаг энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах газартаа очих, буцах замд зарцуулах цаг, эд хөрөнгө байгаа болон оршин суугаа газрын хаяг байршлыг тогтоох, ажиллагаа явуулах зэрэг хугацаа ордог.

2013 оны 1 дүгээр улирлын байдлаар нэг шийдвэр гүйцэтгэгчид оногдох гүйцэтгэх хуудасны тоог авч үзвэл 14324⁷² ажиллагаатай гүйцэтгэх хуудсаа /түдгэлзүүлсэн болон хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэх баримт бичиг ороогүй/ нийт гүйцэтгэгчдээ хувааж үзвэл 77,84 тэгхээр зөвхөн ажиллагаатай гүйцэтгэх хуудсаар дүгнэж үзэхэд шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалал маш их, харъялах тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээ том байдгаас цаг их зарцуулдаг техник ажиллагаа их хийддэг зэрэгээс шалтгаалан шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг орон нутгийн цагаар 06.00 цагаас 22.00 цагийн хооронд шаардлагатай тохиолдолд 22.00 цагаас 06.00 цагийн хооронд явуулдаг иймд шийдвэр гүйцэтгэгч ар гэртээ зарцуулах цаг зав бага байдаг тул түүний амьдрах орон байрны хангалтын асуудлыг шийдвэрлэснээр ажлын бүтээж өснө.

2. Та ажилдаа хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?

А. Сэтгэл хангалуун 8

Сэтгэл хангалуун байдаг шалтгаан нь:

- Төрийн алба хашиж байгаадаа
- Мэргэжилээрээ ажиллаж байгаадаа
- Урамшуулал авч байгаадаа

⁷² 2013 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд биелүүлбэл зохих 586192702,2 төгрөгийн үнийн дүнтэй, 14324 гүйцэтгэх хуудасны 359967619,0 төгрөгийн үнийн дүнтэй 2941 гүйцэтгэх хуудсыг биелүүлж 226231083,2 төгрөгийн үнийн дүнтэй 11383 гүйцэтгэх хуудасны үлдэгдэлтэй гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 20,5%, монгол дүнгийн биелэлт 61,4 % тай ажилласан байна.

В. Сэтгэл хангалуун бус 34

Сэтгэл хангалуун бус байдаг шалтгаан нь:

- Цалин бага
- Хүнд нөхцөлд ажилладаг
- Хэт ачаалалтай
- Дэд ахлагчаас бага цалин авдаг
- Цэргийн цолгүй

Эрхэлсэн ажил албан тушаалдаа сэтгэл хангалуун, дур сонирхолтой байснаар тухайн ажлын үр өгөөж өндөр байна. Судалгаанд хамрагдагсдын 34 нь сэтгэл хангалуун бус учир нь хүнд хэцүү нөхцөлд ажилладаг хэрнээ нийгэм эдийн засгийн баталгаа хангалтгүй байдаг тухай тайлбарласан байна. Сэтгэл хангалуун байдаг шалтгаан нь төрийн албанд ажиллаж байгаадаа, хүний эрхийг хамгаалж, мэргэжлээрээ ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байдаг тухай санал бодолоо илэрхийлсэн байна.

3. Та шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгаа хэр хангагдсан гэж үздэг вэ?

А. Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгаа найдвартай хангагдсан 0

В. Үйл ажиллагаагаа явуулахад наад захын аюулгүй байдлаа хангах эрх зүйн баталгаагүй 42

С. Бусад төрийн албан хаагчийн эрх зүйн баталгаанаас доогуур байдаг 7

Д. Эрх зүйн баталгаа хууль тогтоомжид тусгагдсан ч хэрэгжих боломж бага 8

Энэ асуултанд шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа явуулахад наад захын эрх зүйн баталгаа хангадаагүй, Эрх зүйн баталгаа хууль тогтоомжид тусгагдсан ч хэрэгжих боломж бага гэж судлалгаанд хамрагдсан шийдвэр гүйцэтгэгч нар үзсэн байна.

4. Таныд шийдвэр гүйцэтгэгчээр ажиллахад тулгамдаж буй асуудал?

А. Ажил үүргээ гүйцэтгэсэнтэй холбогдуулж аливаа иргэн, байгууллагаас гаргасан

гомдол, өргөдлийн дагуу бусад хууль, хяналтын байгууллагад шалгагдах үед Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсийн хамгаалалт буюу мэргэжилийн өмгөөлөлийн баг ажилладаг байх 29

В. Бодит ажиллагааны үед гадны халдлага, дайралтаас аюулгүй байдлаа хамгаалуулах баталгаа 34

С. Техник, тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл материаллаг бааз 12

Д. Эдийн засгийн хараат бус байдал 38

Эрх зүйн баталгаа хангалтгүй, цалин хөлс, материаллаг хангамж муу, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад туслах ажилтан байхгүйгээс бүх ажиллагааг гардан гүйцэтгэдэг, өдрийн 8-н цагаас дээш хугацаагаар ажилладаг ч илүү цагийн цалин, хөдөлмөрийн хөлс, албан томилолт бодогддоггүй, сэтгэл зүйн хувьд байнгын дарамт, шахалт тулгардаг байна.

5. Таныд ажил үүргээ гүйцэтгэхэд нэн шаардлагатай эрх зүйн баталгаа юу байна вэ?

Бодит ажиллагааны үед гадны халдлага, дайралтаас аюулгүй байдлаа хамгаалуулах баталгаа, техник, тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл материаллаг бааз, эдийн засгийн хараат бус байдал шаардлагатай гээд ажил үүргээ гүйцэтгэсэнтэй холбогдуулж аливаа иргэн, байгууллагаас гаргасан гомдол, өргөдлийн дагуу бусад хууль, хяналтын байгууллагад шалгагдах үед Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсийн хамгаалалт буюу мэргэжилийн өмгөөлөлийн баг ажилладаг байх заалтгүй шаардлагатай их ажлын хажуугаар бусад байгууллагад дуудагдан шалгагдах маш их дарамт хүндрэл учруулдаг,

6. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр, тэтгэлэг төлөгчид тавьсан хууль

ёсны шаардлагыг эсэргүүцэн, санаатайгаар саад учруулах, сэтгэл санааны дарамт учруулах, биед халдах тохиолдолд байдаг уу?

А. Эсэргүүцэл байдаггүй 0

В. Хааяа л тийм эсэргүүцэлтэй тулгардаг 11

С. Сэтгэл санааны дарамт шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа бүр дээр байдаг иймд гүйцэтгэгч нарыг сэтгэл зүйн дайрамтаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үүднээс албан хаагчдын сэтгэл зүйч ажилладаг байх шаардлагатай 38

Д. Ихэнх тохиолдолд сэтгэл санааны болоод бие махбодын эсэргүүцэлтэй тулгардаг гэнтийн халдлагаас аюулгүй байдлаа хамгаалах техник хэрэгсэл, хамтрагчийн асуудал, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа нэн шаардлагатай байдаг 40

Ихэнх тохиолдолд сэтгэл санааны болоод бие махбодын эсэргүүцэлтэй тулгардаг гэнтийн халдлагаас аюулгүй байдлаа хамгаалах техник хэрэгсэл, хамтрагчийн асуудал, ШГАлбаны дэргэд сэтгэл зүйч байх шаардлагатай, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа маш чухал өндөр үнийн дүнтэй болон анхаарал татсан, хүч шаардагдсан ажиллагаанд цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг заавал оролцуулж энэ тухай хуулинд үүрэгжүүлэх шаардлагатай.

7. Таны дүрэмт хувцас ажил үүргээ гүйцэтгэхэд тохиромжтой юу?

А. Тохиромжтой 0

В. Тохиромжгүй 42

Шийдвэр гүйцэтгэгчийн дүрэмт хувцас шаардлага хангадаггүй ёслол болон ажиллагааны тохирсон, цаг үеийн шаардлага хангасан байх хэрэгтэй гэсэн

саналыг чөлөөт санал асуулгаар санал оруулсан байна.

8. Шийдвэр гүйцэтгэх албаны жолоочын эрх зүйн байдал

А. Цэргийн орон тоон дээр ахлагч жолооч ажиллаж байна 30

В. Энгийн орон тоон дээр энгийн жолооч ажиллаж байна 10

С. Шийдвэр гүйцэтгэгч өөрөө тээврийн хэрэгсэлээ жолоодож байна 8

Д. Ялтан жолоочтойгоор шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд явж байна 2

Шийдвэр гүйцэтгэх бүхий л ажиллагаанд жолоочын үүрэг маш их учир нь тээврийн хэрэгсэлийн аюулгүй бүрэн бүтэн байдал, ажиллагаагаар хураасан эд зүйлийг бүрэн бүтэн албанд хүргэх үүргийг хүлээж байдаг гэтэл ялтан жолоочтой шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд явж байгаа нь шийдвэр гүйцэтгэгч төдийгүй тухайн ажиллагааны нууцлал аюулгүй байдал бүрэн алдагдаж байна. Иймд ялтан жолоочийн асуудлыг бүрэн шийдвэрлэж энгийн эсвэл цэргийн жолооч байлгах зайлшгүй шаардлагатай.

Дүгнэлт:

Энэхүү судалгаа болон Шийлвэр гүйцэтгэгч нарын анхдугаар нэгдсэн зөвлөгөөн дээр тавигдсан илтгэл, хэлэлцүүлэгээс хархад шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалал их, өдрийн 8-н цагаас дээш хугацаагаар ажилладаг ч илүү цагийн цалин, хөдөлмөрийн хөлс, албан томилолт бодогддоггүй, сэтгэл зүйн хувьд байнгын дарамт, шахалт тулгардаг, цалин хөлс, материаллаг хангамж муу, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад туслах ажилтан байхгүйгээс бүх ажиллагааг гардан

гүйцэтгэдэг ба нийт шийдвэр гүйцэтгэгч⁷³ нарын ихэнх нь эмэгтэй байдаг учир зайлгүй туслах ажилтан шаардагддаг тулгардаг байна.

Ажиллагааны явцад хувийн болон баримт бичгийн аюулгүй байдлаа хангах хамгаалах механизм бүрдээгүй, нийгэм, эдийн засгийн баталгаа бусад төрийн тусгай албан хаагчийн нэгэн адил хангагдаагүй хэрнээ хүлээлгэх хариуцлага⁷⁴ өндөр, албаны тээврийн хэрэгслийн хүрэлцээ дутмаг байдгаас хувийн тээврийн хэрэгсэлээр ажиллагаанд явдаг нь тус ажиллагааны болоод шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл хангагдаагүйг харуулж байна.

Ажиллагааны үед хөндлөнгийн гэрч оролцуулах хүндрэлтэй, шийдвэр гүйцэтгэгчийн үйлдэл, үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулсан, хэл амаар доромжилсон, бие эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд хөндөгдсөн эрхээ хамгаалуулахаар бусад хууль хяналтын байгууллагад хандхад захиргааны хариуцлагаас хэтэрдэггүй нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан эрх зүйн баталгаа хангагддаггүйн нэгэн илрэл юм.

Ажил үүргээ гүйцэтгэсэнтэй холбогдуулж аливаа иргэн, байгууллагаас

гаргасан гомдол, өргөдлийн дагуу бусад хууль, хяналтын байгууллагад шалгагдах үед Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсийн хамгаалалт буюу мэргэжилийн өмгөөлөлийн баг ажилладаггүйгээс их ажлын хажуугаар бусад байгууллагад дуудагдан шалгагдах маш их дарамт хүндрэл учруулдаг зэрэг олон хүндрэл бэрхшээл тулгардаг нь судалгаанаас харагдаж байна.

Иймд хуульд тусгагдсан материаллаг шинжтэй эрх зүйн болон нийгмийн баталгаануудаас гадна хамгийн чухал нь шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны үед хөндлөнгөөс бусад этгээд оролцохгүй байх, шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны дагуу тавьсан шаардлагыг хүлээн авсан этгээд заавал биелүүлэх, шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд нөлөөлөх гэж оролдсон, бие махбодь эрүүл мэндэд халдсан, биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг хуульд тодорхой тусгах, орон байр, гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хамгаалах, ажиллагаанд хэрэглэгдэх техник хэрэгсэлийг сайжруулж дүрс, дуу бичлэгийн овор бага, ажиллагаанд ямар нэгэн байдлаар саад учруулахгүйгээр төв байгууллагатайгаа шууд холбогддог техник хэрэгсэлтэй байвал шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд заавал хөндлөнгийн гэрч шаардлагагүйгээс гадна шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангахад нэгэн хөшүүлэг болно.

Тусгай хэрэгсэлийн хангамж, ажиллагааны болон эдийн засгийн хараат бус байдал, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны жолооч, тээврийн хэрэгслийн асуудлыг улсын хэмжээнд нэгдсэн журмаар зохицуулах зэрэг эрх зүйн баталгааг практик дээр бүрэн дүүрэн хэрэгжих нөхцлийг хуульд тусгах замаар Монгол Улсын Үндсэн

⁷³ Нийт гүйцэтгэгч нарыг хүйсээр нь авч үзвэл эрэгтэй 59, эмэгтэй 125, боловсролоор нь ахлах гүйцэтгэгчээс 10 магистр, 25 бакалавр, шийдвэр гүйцэтгэгч нараас 23 магистр, 161 бакалавр, Улсын хэмжээнд нийт 190-н тойрог байх ёстойгоос 6 тойргийн орон тоо дутуу байна

⁷⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 136 дугаар зүйл, УБ., 2002.,

136.1.Шийдвэр гүйцэтгэгчид зорчлийн шинж байдлыг харгалзан дараахь сахилгын шийтгэл оногдуулна:

136.1.1.сануулах;

136.1.2.шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгох.

хуулинд тусгагдсан⁷⁵ төрийн чиг үүргийн хэрэгжүүлж шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг нэгдсэн байдлаар зохицуулах, албан хаагчийн хариуцлага, ёс зүйн болон сахилгын дүрмийг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах зарчмын шинэлэг зохицуулалт бий болгох, албан хаагчийн үйл ажиллагаа байгууллагаас бус хуулиас илүү хамааралтай байх нөхцөлийг бүрдүүлэн төрийн хүнд сурталыг⁷⁶ арилгаж иргэнийхээ⁷⁷ хөндөгдөж эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэж үзэж дараах саналуудыг оруулж байна.

- Шийдвэр гүйцэтгэгчийг амьдрах орон байраар хангах боломжтой нөхцөлийг бүрдүүлэх алба хэсэг бүрэн зохион байгуулах
- Дотоод хяналт шалгалт аюулгүй байдлын хэлтсийн хамгаалалт, чиг үүргийг практикт хэрэгжүүлэн өмгөөлөл хууль зүйн баг ажилладаг болгох
- Алба хаагчдын сэтгэл зүйчийг ажиллуулах, бусад байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах тал дээр анхаарах
- Нийгэмд шийдвэр гүйцэтгэгчийн ажил үүргийг ойлгох, хүндэтгэлтэй хандах асуудал бага байдаг иймд шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааг сурталчилсан ажил зохион байгуулж нийгмийн сэтгэл зүйг өөрчлөх

⁷⁵ Монгол Улсын Үндсэн хууль 1992., 19 дүгээр зүйл., 19.1 дэх хэсэг "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зорчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ олно хариуцна"

⁷⁶ Төрийн хүнд суртал гэдгийг төрийн үйл ажиллагааг хэвийн тасралгүй явуулахад чухал үүрэг гүйцэтгэж буй албан хаагчийнхаа эрх зүйн баталгааг хуулинд тодорхой тусгаж эрх зүйн баталгааг бүрэн хангаагүй байна гэсэн утгаар энд авч үзсэн.

⁷⁷ Монгол Улсын төрийн эжинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тээврийн хэрэгсэл, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны замын маршрутын аюулгүй байдал, жолоочийн асуудлыг шийдвэрлж нэг мөр болгох хэрэгтэй гэсэн саналуудыг оруулж байна.